

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/03-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
	Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Аудитор: З.Золбоо
	Утас: 70362442 Цахим хаяг: Zolbooz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
3. Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8. Аудитын гол асуудал	15
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/03-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА
П. ЭРДЭНЭСАЙХАН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч. ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,716,398.00	3,428,550.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,716,398.00	3,428,550.00
354	Хангамжийн материал	3,716,398.00	3,428,550.00
35410	Бичиг хэргийн материал	1,349,549.00	1,184,500.00
35420	Аж ахуйн материал	2,366,849.00	2,244,050.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	59,688,008.76	52,726,787.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	59,688,008.76	52,726,787.20
392	Биет хөрөнгө	58,918,008.76	52,341,787.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	21,587,907.00	21,587,907.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(918,634.32)	(1,377,951.48)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,249,999.92	31,249,999.92
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,166,666.60)	(9,374,999.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	10,683,564.23	10,683,564.23
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,371,444.44)	(5,206,559.88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,682,716.94	6,213,659.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,829,433.97)	(1,433,831.97)
393	Биет бус хөрөнгө	770,000.00	385,000.04
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(384,999.96)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	63,404,406.76	56,155,337.20
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	63,404,406.76	56,155,337.20
51	Засгийн газрын хувь оролцоо	63,404,406.76	56,155,337.20
512	Хуримтлагдсан үр дүн	63,404,406.76	56,155,337.20
51210	Өмнөх үеийн үр дүн	63,404,406.76	63,404,406.76
51220	Тайлант үеийн үр дүн	-	(7,249,069.56)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	63,404,406.76	56,155,337.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	189,692,017.24	156,441,352.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,017,941.15	5,518,407.84
120	Нийтлэг татварын бус орлого	25,017,941.15	5,518,407.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,769,277.00	2,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,769,277.00	2,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	164,674,076.09	150,922,944.46
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,955,000.00	6,747,139.73
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,955,000.00	6,747,139.73
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	155,719,076.09	144,175,804.73
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	173,220,983.31	163,690,421.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	173,220,983.31	163,690,421.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	171,820,983.31	162,235,721.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	119,987,541.79	114,709,686.64
210101	Үндсэн цалин	74,592,215.24	75,515,245.03

210102	Нэмэгдэл	23,189,085.33	24,674,129.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,550,000.00	2,124,000.00
210104	Урамшуулал	9,038,096.00	1,874,130.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,618,145.22	10,522,181.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,106,660.30	14,889,257.82
210201	Тэтгэврийн даатгал	9,340,572.62	10,679,470.75
210202	Тэтгэмжийн даатгал	1,129,173.41	1,083,547.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	876,487.11	931,849.74
210204	Ажилгүйдлийн даатгал	356,398.18	203,529.74
210205	Эрүүл мэндийн даатгал	3,404,028.98	1,990,859.69
2104	Хангамж, бараа материалын зардал	9,450,610.00	9,377,198.00
210401	Бичиг хэрэг	2,614,560.00	2,742,124.07
210402	Тээвэр, шатахуун	3,770,000.00	3,514,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,665,900.00	2,607,875.93
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	380,000.00	250,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	20,150.00	-
210408	Бараа материал ақталсны зардал	-	262,848.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,347,950.00	2,716,700.00
210604	Урсгал засвар	5,347,950.00	2,716,700.00
2107	Томиллолт, зочны зардал	4,428,000.00	5,299,900.00
210702	Дотоод албан томиллолт	4,428,000.00	5,299,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,860,614.00	4,812,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,028,150.00	3,716,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	171,464.00	120,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	685,000.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,639,607.22	10,430,279.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,639,607.22	10,430,279.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,400,000.00	1,454,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,400,000.00	1,454,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	1,454,700.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	16,471,033.93	(7,249,069.56)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	83,100.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	18,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(83,100.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	16,387,933.93	(7,249,069.56)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	47,016,472.83	47,016,472.83
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	47,016,472.83	47,016,472.83
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Тайлант үеийн үр дүн	-	-	16,387,933.93	16,387,933.93
6	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	63,404,406.76	63,404,406.76
7	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	63,404,406.76	63,404,406.76
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	63,404,406.76	63,404,406.76
10	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
11	Тайлант үеийн үр дүн	-	-	(7,249,069.56)	(7,249,069.56)
12	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	56,155,337.20	56,155,337.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	169,443,353.09	152,922,944.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,769,277.00	2,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,769,277.00	2,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,769,277.00	2,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,769,277.00	2,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	164,674,076.09	150,922,944.46
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,955,000.00	6,747,139.73
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,955,000.00	6,747,139.73
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	155,719,076.09	144,175,804.73
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	168,093,353.09	152,922,944.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	168,093,353.09	152,922,944.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	166,693,353.09	151,468,244.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	119,994,829.53	114,560,481.84
210101	Үндсэн цалин	71,867,589.29	74,560,188.58
210102	Нэмэгдэл	26,238,512.09	25,424,240.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,707,500.00	2,179,741.31

210104	Урамшуулал	9,038,096.00	1,874,130.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,143,132.15	10,522,181.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,138,649.56	15,038,462.62
210201	Тэтгэврийн даатгал	11,546,110.01	10,376,027.23
210202	Тэтгэмжийн даатгал	720,269.10	1,092,012.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	493,767.60	873,590.21
210204	Ажилгүйдлийн даатгал	185,248.38	354,467.49
210205	Эрүүл мэндийн даатгал	2,193,254.47	2,342,364.99
2104	Хангамж, бараа материалын зардал	9,646,460.00	9,040,000.00
210401	Бичиг хэрэг	2,830,560.00	2,637,124.07
210402	Тээвэр, шатахуун	3,770,000.00	3,465,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,665,900.00	2,607,875.93
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	380,000.00	330,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,347,950.00	2,716,700.00
210604	Урсгал засвар	5,347,950.00	2,716,700.00
2107	Томилолт, зочны зардал	4,428,000.00	5,299,900.00
210702	Дотоод албан томилолт	4,428,000.00	5,299,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,137,464.00	4,812,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,305,000.00	3,716,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	171,464.00	120,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	685,000.00	200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,400,000.00	1,454,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,400,000.00	1,454,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00	1,454,700.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,350,000.00	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,350,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,350,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	1,350,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,350,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,350,000.00)	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	146,375,200.00	146,175,804.73	199,395.27	99.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	146,375,200.00	146,175,804.73	199,395.27	99.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	144,920,500.00	144,721,104.73	199,395.27	99.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	109,244,700.00	109,210,481.84	34,218.16	99.97
210101	Үндсэн цалин	63,784,100.00	69,210,188.58	(5,426,088.58)	108.51
210102	Нэмэгдэл	27,522,000.00	25,424,240.11	2,097,759.89	92.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,772,000.00	2,179,741.31	592,258.69	78.63
210104	Урамшуулал	4,610,200.00	1,874,130.00	2,736,070.00	40.65
210105	Гэрээт ажлын хөлс	10,556,400.00	10,522,181.84	34,218.16	99.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,856,500.00	14,691,322.89	165,177.11	98.89
210201	Тэтгэврийн даатгал	10,454,600.00	10,187,127.02	267,472.98	97.44
210202	Тэтгэмжийн даатгал	1,100,500.00	1,092,012.70	8,487.30	99.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	880,400.00	873,590.21	6,809.79	99.23
210204	Ажилгүйдлийн даатгал	220,100.00	354,467.49	(134,367.49)	161.05
210205	Эрүүл мэндийн даатгал	2,200,900.00	2,184,125.47	16,774.53	99.24
2104	Хангамж, бараа материалын зардал	9,040,000.00	9,040,000.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	2,600,000.00	2,637,124.07	(37,124.07)	101.43
210402	Тээвэр, шатахуун	3,400,000.00	3,465,000.00	(65,000.00)	101.91
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,640,000.00	2,607,875.93	32,124.07	98.78
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,000.00	330,000.00	70,000.00	82.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,666,700.00	1,666,700.00	-	100.00
210604	Урсгал засвар	1,666,700.00	1,666,700.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	5,299,900.00	5,299,900.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	5,299,900.00	5,299,900.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,812,700.00	4,812,700.00	-	100.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,716,700.00	3,716,700.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	120,000.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	200,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,454,700.00	1,454,700.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,454,700.00	1,454,700.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,454,700.00	1,454,700.00	-	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	146,375,200.00	146,175,804.73	199,395.27	99.86
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	144,375,200.00	144,175,804.73	199,395.27	99.86
320001	Орон нутгийн төсвөөс	144,375,200.00	144,175,804.73	199,395.27	99.86
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	17.00	17.00	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	8.00	8.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	6.00	6.00	-	100.00
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	8.00	8.00	-	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	7.00	7.00	-	100.00
650010	Гэрээт ажилтан	1.00	1.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,855,000.00	6,747,139.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,855,000.00	6,747,139.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,855,000.00	6,747,139.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,350,000.00	5,350,000.00
210101	Үндсэн цалин	5,350,000.00	5,350,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	455,000.00	347,139.73
210201	Тэтгэврийн даатгал	455,000.00	188,900.21
210205	Эрүүл мэндийн даатгал		158,239.52
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,050,000.00	1,050,000.00
210604	Урсгал засвар	1,050,000.00	1,050,000.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	104,860.27
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,855,000.00	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газар /цаашид Орон нутгийн өмчийн газар гэх/-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэж байх, автомашины шатахууны нормыг шинэчлэн тогтоох, шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Золбоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 38 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон нутгийн өмчийн харилцааг зохицуулах,
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэж байна.

Тус газрын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 163,690.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,732.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,299.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,249.1 мянган төгрөгөөр буюу 11.7 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	3,716.4	3,428.6	(287.8)
Үндсэн хөрөнгө	59,688.0	52,726.8	(6,961.2)
Нийт хөрөнгө	63,404.4	56,155.3	(7,249.1)
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	63,404.4	56,155.3	(7,249.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	63,404.4	56,155.3	(7,249.1)

Бараа материалын дансны үлдэгдэл 3,428.6 мянган төгрөг болж өмнөх оноос 287.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 9,138.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон Магнай трейд ХХК-с 49.3 мянган төгрөгийн шатахууны урамшуулал авч, 262.7 мянган төгрөгийн материалыг актлан, 9,213.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 70,505.1 мянган төгрөг болж өмнөх оноос 3,469.1 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлээрээ өртгөө нөхсөн 6,938.2 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасч, 3,469.1 мянган төгрөгөөр үнэлж, шинэчлэн тогтоосноос шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 56,155.3 мянган төгрөг болж 7,249.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалжээ.

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 33,250.7 мянган төгрөгөөр буюу 17.5 хувиар буурсан нь орон нутгийн төсвийн санхүүжилт буурсантай холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 9,530.6 мянган төгрөгөөр буюу 5.5 хувиар буурсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын, эд хогшил, урсгал засварын, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлууд буурснаас голлон шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 203,569.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 57,194.0 мянган төгрөгөөр бууруулж, 146,375.2

мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 18,445.8 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 3,332.4 мянган төгрөг, томилолтын зардлыг 3,850.1 мянган төгрөг, урсгал засварыг 3,101.0 мянган төгрөг, мэдээлэл сурталчилгааны зардлыг 3,200.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 3,080.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 11,100.6 мянган төгрөгөөр бууруулан баталснаас голлон шалтгаалсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 146,375.2 мянган төгрөгийн төсөв баталж, 144,375.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 2,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 144,375.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоос 2,000.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 146,175.8 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл 99.8 хувьтай тайлагнагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын А/348 дугаар захирамжаар төлөвлөгөөнөөс давсан 6,855.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, цалин, хөлс болон нэмэгдэл урамшилд 5,350.0 мянган төгрөг, НДШ-д 347.1 мянган төгрөг, урсгал засварт 1,050.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайлан орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ТӨБЗГ-аас аймгийн Орон нутгийн өмчийн газрын дансанд цахим тендерийн хураамжаас 8,855.0 мянган төгрөгийн орлого төвлөрсөн бөгөөд тус газраас тендерт оролцсон аж ахуйн нэгжүүдийн бүртгэлд үндэслэж цахим тендерийн хураамж бүрэн төвлөрсөн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Цаашид үйл ажиллагааны орлогын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Орон нутгийн өмчийн газар нь шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 139 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн бол 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Орон нутгийн өмчийн газрын тайлант оны үйл ажиллагаанд 146,375.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 146,175.8 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.2 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх онд өгсөн төлбөрийн актын хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 413.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулан ажилласан байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн актын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	413.0	1	413.0	100
Дүн	1	413.0	1	413.0	100.0

/мянган төгрөг/

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,476.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 257.5 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 9,219.2 мянган төгрөгийн 3 алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

1. Завсрын аудитаар илэрсэн ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүйн улмаас 4 албан хаагчид 257.5 мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон зөрчлийг жилийн эцэст биеэр амрааж залруулсан тул залруулсан алдаагаар бүртгэлээ.

4.2 Зөвлөмж

Аудитаар 3 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

1. Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 225.0 мянган төгрөгийн худалдан авалтын анхан шатны баримт бөөн дүнгээр шивэгдсэн, 7,174.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Байгууллагын Sonata-7 маркийн автомашины 100 км гүйлтэд зарцуулах нормд хэмжилт, сорилт хийж шинэчлэн тогтоолгүйгээр 100 км-т 12 литрээр / норм нь 5.8 литр / тооцон, нийт 1,820.0 мянган төгрөгийн хийн түлш олгосон байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Автомашинь 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”, 3 дугаар хавсралтаар батлагдсан “Автомашинь шатахуун зарцуулалтын нормьг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ”-г зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна. Цаашид автомашинь шатахууны нормьг бодитоор тогтоон, мөрдөж ажиллах.

3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Шилэн дансанд мэдээлбэл зохих 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.4, 6.8 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Сэлэнгэ аймгийн Орон нутгийн өмчийн газар	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
			Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	5	9,476.7	1	257.5			1	-	3	9,219.2